



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 03 сарын 14 өдөр

Дугаар А/99

Мандалговь

Архи, согтууруулах ундаа худалдах тусгай зөвшөөрлийн эрх олгох, сунгах, хүчингүй болгох тухай

Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2, 14 дүгээр зүйлийн 14.1.1, 16 дугаар зүйлийн 16.2.5, Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.7, 14 дүгээр зүйлийн 14.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Баянжаргалан сумын "Түвшин энгүүмэл", ХХК-ний хүнсний дэлгүүрт архи, согтууруулах ундаа худалдан борлуулах тусгай зөвшөөрлийн эрхийг 2022 оны 03 дугаар сарын 14-ний өдрөөс 2024 оны 03 дугаар сарын 14-ний өдөр хүртэлх хугацаагаар олгосугай.

2. Өлзийт сумын "МБЦДС", "ДДБГА", "БИЙВАА" ХХК-ний хүнсний дэлгүүрийн архи, согтууруулах ундаа худалдан борлуулах тусгай зөвшөөрлийн эрхийг 2022 оны 03 дугаар сарын 14-ний өдрөөс 2024 оны 03 дугаар сарын 14-ний өдөр хүртэлх хугацаагаар тус тус сунгасугай.

3. Баянжаргалан сумын "Баян бүрдийн хишиг" хоршооны хүнсний дэлгүүрийн архи, согтууруулах ундаа худалдан борлуулах тусгай зөвшөөрлийн эрхийг 2022 оны 03 дугаар сарын 14-ний өдрөөс хүчингүй болгосугай.

4. Гарсан шийдвэрийг холбогдох газруудад хуулийн хугацаанд мэдэгдэхийг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Н.Эрдэнэ-Очир), тухайн аж ахуй нэгжийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Цагдаагийн газар(Б.Мөнхбат), Татварын хэлтэс (М.Туяацэцэг), Мэргэжлийн хяналтын газар (Ш.Төрбат), холбогдох сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА Ц.МӨНХБАТ



4822100238